



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/419

Улаанбаатар хот

Шингэрүүлсэн хийн халаагуурын төхөөрөмж туршилтын журмаар суурилуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоол, 2018 оны 62 дугаар тогтоол, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10/05 дугаар тогтоолоор батлагдсан “Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 2 дугаар зүйлийн 2.5-1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дүүргийн гэр хорооллын айл өрхүүдийн шингэрүүлсэн хийн хэрэглээг нэмэгдүүлэх, хийн хэрэглээг иргэдэд сурталчилан таниулах зорилгоор гэр хорооллын бүрэн дулаалгатай нэг айл өрхөд туршилтын журмаар хийн халаагуурын иж бүрдэл суурилуулах ажлыг зохион байгуулсугай.
2. Хийн халаагуурын иж бүрдлийг суурилуулах ажилд шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргахыг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган, үр дүнг танилцуулахыг Эдийн засаг, худалдаа, үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА